

ГАДААД АЮУЛГҮЙ БАЙДАЛ

МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО БА ТҮВИЙГ САХИХ СТАТУС

Г.Базарваань

Стратегийн судалгааны хяруулэнгийн Оршин тогтнохуйн судалгааны
секторын эрхлэгч, доктор (Ph.D)

Оршил

Аливаа улсын гадаад бодлого хийгээд аюулгүй байдлын асуудлыг батлан хамгаалах бодлоготой холбож гэмээ нь улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхийг баталгаажуулах цогц ойлголтыг бий болгодог. Эдгээ олон улсын амьдралд үрнэх үйл явдлыг авч үзвэл, даяарын аюулгүй байдлын тогтолцоо улам хэврэг болох, дэлхий нийтийн харилцаанд шинэ дэг журам үүсэх хандлагатай болж байна. Олон улсын харилцаанд шинэ дэг журам бий болох эл хандлага зарим улс орныг нягтруулан ойртуулах бол заримыг нь бүрхүндийрүүлэн холдуулах байдал руу тлхэж байна.

Ийм онцлог бүхий цаг үед Монгол Улс батлан хамгаалах бодлогын үндэс гэх чухаг баримт бичгийг боловсруулсан түүдийгүй Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Монгол Улс байнга түүвийг сахих тухай НҮБ-ын Ерөнхий ассамблейн 70 дугаар хурлын үеэр мэдэгдсэн юм.

Энэхүү үгүүлэлд Монгол Улсын түүвийг сахих байр суурь хийгээд Батлан хамгаалах бодлогын тухай, тэдгээрийн уялдаа холбоог товч танилцуулж, уншигчдад Монгол Улсын байнга түүвийг сахих статусын талаар нэгдсэн ойлголт үгн.

Нэг. Монгол улсын батлан хамгаалах бодлогын үндэс

Монгол Улсын батлан хамгаалах салбарын тулгуур баримт бичгийн нэг Батлан хамгаалахын “Цагаан ном”-ыг 1997 онд анх гаргасан түүхтэй. Тэр үед хуучнаар Зүвлүлт холбоот Улсад аюулгүй байдал, батлан хамгаалахын чиглэлээр суралцаж онол, дадлагын мэдлэгтэй болсон хүмүүс уг “Цагаан ном”-ыг боловсруулсан байдаг. Гэвч энэ нь тухайн үедээ олон улсын нийтлэг жишгийн дагуу үүрийн улсын батлан хамгаалах тогтолцоог ил тод, тунгалаг болгосон шинэлэг ажил байв. Эдгээ уг “Цагаан ном” гарч байсан ойлголт, шаардлага болон тухайн үеийн улс түр, эдийн засаг, нийгмийн харилцаа эрс үүрчлүгджээ.

Нэгдүгээр дэлхийн геополитик харьцуулшгүй өөрчлөгдөж, анхны “Цагаан ном” боловсруулж байсан орчин нөхцөл, мэдлэг, мэдээлэлд өлөмж хувьсал гарчээ. Өөний дагуу манай улсын аюулгүй байдлын орчин ч мөн өөрчлөгдсөн юм.

Хэрхэвч хоёр улс болох ОХУ болон БНХАУ-ын хичин чадал, гадаад бодлого болон аюулыг өнөлөх өнөлөмж өөрчлөгдсөнтэй холбоотойгоор олон улсын харилцаанд олон ээдрээтэй асуудал өссөн явдал манай аюулгүй байдлын орчинд нөлөөлж, тодорхой хэмжээгээр мэдрэгдэх болов. Сүүлийн жилүүдэд хоёр хэрхэвч орон батлан хамгаалах чадавхаа нэмэгдүүлэх, шинэ өөийн зэвсэг техникээр сэлбэх өөйл ажиллагааг идэвхтэй явуулж байна. Өөнийг хэрхэвч орнуудын харилцаанд цаашид батлан хамгаалах, цэрэг техникийн салбарын хөгжил ихээхэн нөлөөлөх эрсдлийг бий болголоо. Өөнийг өнгийн өгөөр тайлбарлавал гадаад, дотоод аюулгүй байдлыг сахин хамгаалахад батлан хамгаалах, эдийн засгийн чадавх ихээхэн нөлөөтэй болохыг тодруулж байна. Энэ нь зэвсэг, техникийн төдийгүй эдийн засгийн чадавх сул жижиг улс аюулгүй байдлаа хангахын тулд нэгдмэл, цогц, ухаалаг тогтолцоог бий болгох шаардлагыг өөсгэлээ.

Аюулгүй байдлын цогц асуудлыг зөвхөн цэрэг, эсвэл цагдаа, тагнуулын байгууллагынхан тус тусдаа мэдээд бие дааж хэрэгжүүлдэг ажил биш.

Төвчлөн Монгол Улсын батлан хамгаалахын анхны “Цагаан ном”-дан ганц батлан хамгаалах салбарын бодлого, зорилгыг тусгасан явдал энэ цаг өөийн шаардлагыг хангах боломжгүй болов. Өөнгийг засаж залруулах өөднээс нэн тэргүүнд Монгол Улс батлан хамгаалахынхаа тулгуур баримт бичгийг өөрчлөх шаардлагатай болсон юм. Ингэснээр манай улс орших газар зүй, бөс нутгийн аюулгүй байдлын нийтлэг өнөлгөөг бодитойгоор гаргаж, тэрхүү өнөлгөөнд тулгуурлан аюулгүй байдлын өөрчлөлт ямар агуулга, хэлбэрээр Монгол Улсад нөлөөлж болохыг урьдчилан төсөөлөх, холбогдох бодлого, арга хэмжээг алс хэтийн хугацаатай холбон таамаглах, боловсруулах шаардлагатай болжээ.

Дурдсан шаардлагаас өөдөн Монгол Улс Батлан хамгаалах бодлогын өөдэс хэмээх баримт бичгийг боловсруулж, 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдөр /УИХ-ын 85 дугаар тогтоол/ УИХ-аар баталсан юм. Энэхүү баримт бичигт орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бэхжүүлэх, олон улсын болон бөс нутгийн аюулгүй байдлыг сахин хамгаалах өөйлсэд идэвхтэй оролцож, цэргийн итгэлцлийг гүнзгийрүүлэх, урт, дунд хугацааны хөтөлбөр, төслөдийг хэрэгжүүлэх

замаар Зэвсэгт хичний шинэчлэлийг гүнзгийрүүлж, мэргэжлийн чиг баримжаатай, чадварлаг болгон хөгжлийн шинэ шатанд гаргах тухай цогцоор авч үзжээ¹²². Үүнд,

- Батлан хамгаалах үйл ажиллагаа бүх нийтийн үйл хэрэг байх зарчимд тулгуурлан төрийн батлан хамгаалах бодлогыг шинэчлэх;
- батлан хамгаалах төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг нэмэгдүүлэх;
- зэвсэгт хичний нэгдмэл байдлыг хангаж, мэргэжлийн цэрэгт суурилсан орчин үеийн Зэвсэгт хичинтэй болох;
- хил хамгаалах бодлогыг шинээр тодорхойлж, улсын хилийн хамгаалалтад орчин үеийн зэвсэглэл, техникийг нэвтрүүлэх;
- зэвсэгт хичний энхийг дэмжих ажиллагааны чадавхийг бэхжүүлж, үндэсний байнгын хичний тогтолцоо бүрдүүлэх;
- иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх. Зэвсэгт хичинд эх оронч үзэл, хичмэлжил, хичний хөгжил, төлөвшилийн орчныг бүрдүүлэх;
- цэргийн алба хаагчдын эрх зүй, нийгмийн баталгааг сайжруулах;
- цэргийн алба хаагчдыг шинэ бүтээн байгуулалтад оролцуулах арга хэмжээ авах зэрэг асуудлыг тусгасан байна.

Хоёр. Монгол улсын батлан хамгаалах бодлого ба төвийг сахих статус

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, “Монгол Улс байнга төвийг сахих” статусыг албан ёсоор хадгалах тухай санаачлагыг 2015 оны 9 дүгээр сарын 08-нд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын Зөвлөлд өргөн барьсан билээ.

Энэ санаачлагыг АБЗ хүлээн авч дэмжсэн бөгөөд 2015 оны 10 дугаар сарын 20-нд “Монгол Улс байнга төвийг сахих” тухай хуулийн төслийг Монгол Улсын Их хуралд өргөн барьсан юм. Үүний сацуу Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Б-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар хүндэтгэлийн хуралдаанд уг хэлэхдээ “Монгол Улсын байнга төвийг сахих” асуудлын тухай товч танилцуулсан болно.

Монгол Улсын “байнга төвийг сахих” статусыг дэмжсэн, эсэргүүцсэн хэд хэдэн нийтлэл, ярилцлага манай хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан ба эл асуудлаар телевизийн олон сувгаар хэлэлцүүлэг үргэсэн юм. Энэ нь, Монгол Улсын хувьд гадаад бодлогын асуудлаар нээлттэй хэлэлцсэн анхны тохиолдол болсон гэхэд хилсдэхгүй биз ээ.

¹²²Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс

Төвийг сахих тухайд улс төрч, судлаач нар харилцан адилгүй байр суурьтай байна. Монгол Улсын хувьд гадаад бодлого, аюулгүй байдлын асуудлаар ихэнх тохиолдолд харьцангуй нэгдмэл санаа бодолтой байдаг. Иймд төвийг сахих тухай асуудлаар мөн адил нэгдсэн ойлголттой болох, эсрэг тэсрэг байр суурийг нэгтгэх, ард иргэдэд учирлан тайлбарлах шаардлага урган гарч байна.

Төвийг сахих статусын тухай ерөнхий ойлголт

Төвийг сахих тухай ойлголт XIX зууны дунд үеэс, олон улсын амьдралд хэвшиж тогтсон байна. Европ тивд он удаан жил үргэлжилсэн дайны явцад, олон улсын харилцаа, эрх зүйд “төвийг сахих” тухай ойлголт үүсжээ. Ингэснээр, Швейцар, Бельги¹²³, Люксембург¹²⁴ гэдэг гурван орон, олон улсын гэрээгээр Европт төдийгүй дэлхийд, төвийг сахих статус бөхий анхны улс болсон байдаг.

Энэ статус дайны үед, эсвэл тайван цагт төвийг сахих гэсэн хоёр үндсэн хэлбэртэй. Тодруулбал, зөвхөн дайны үед төвийг сахих ба тайван цагт энэ статусаа баримтлахгүй байх боломжтой нэг хэлбэр байна. Мөн дайны болон тайван цагийн аль ч үед төвийг сахих хоёрдахь хэлбэр бий. Ийм хэлбэрийг олон улсын эрх зүйд “байнгын” хэмээн тодотгодог болно. Байнга төвийг сахих статустай улс, дайнд, бусад улс хоорондын маргаанд оролцохгүй, аль нэгэн талыг дэмжихгүй байх эрхтэй байна.

Олон улсын эрх зүйн хувьд “Төвийг сахих” статус төдийлөн хөгжсөнгүй байдаг. Тухайлбал, 1907 оны “Хуурай замын дайны үед төвийг сахисан гэрэн, этгээдийн эрх, цэргийн тухай Хаагийн V конвенц” болон “Тэнгисийн дайны үед төвийг сахисан гэрний эрх, цэргийн тухай Хаагийн XIII конвенц¹²⁵”-оор төвийг сахих улсын эрх цэргийг тодорхойлжээ. Ингэснээр, төвийг сахих статус авах гэж буй улс тус бүр дээрх хоёр конвенцид заасан үндсэн зарчмыг мөрдөх учиртай ч цэргийн онцлогийг, дотоодын хууль эрх зүйн баримт бичигтээ¹²⁶ тусгах боломжтой болсон аж.

Төвийг сахиж буй улс үндэстний хувьд, цэргийг хамгаалах зэвсэгт хүчинтэй байх, зэвсэгт хүчнээ хөгжүүлэх, олон улсын харилцаанд идэвхитэй байр сууринаас оролцох эрхтэй. Цэрлээр хэлбэл, Швейцар, Швед шиг цэргийг хамгаалах хүчирхэг зэвсэгт хүчинтэй байх боломжтой, эсвэл

¹²³ 1831-1919 оны хооронд Бельги улс байнга төвийг сахих статусыг хадгалж байв.

¹²⁴ 1867-1944 оны хооронд Люксембург төвийг сахих улс байв.

¹²⁵ Эл хоёр конвенцийн орчуулгыг хавсаргасан байгаа.

¹²⁶ Хууль, тогтоомж болон олон улсын гэрээгээр төвийг сахих статуса баталгаажуулах практик бий.

жижигхэн Коста-Рика¹²⁷ шиг ерөө сөөг зэвсэгт хөгжингүй байх бас нэгэн хувилбар байна.

- Төвийг сахих статустай улс дараах байдсан хариуцлага хөдлөнө. Өдөнд,
- Дайны өд тэр дайнд татагдан оролцохгүй, нутаг дэвсгэрээ аль нэгэн талд ашиглуулахгүй байх,
 - Тайван цагт цэргийн аливаа эвсэл, холбоонд нэгдэхгүй байх.

- Өдөөс дайны өд дараах өд рөг хөдлөнө. Тухайлбал,
- өддэсний зэвсэгт хөгчнөө дайтагч аль нэг талд ашиглуулахгүй байх, нутаг дэвсгэрээ ашиглуулахгүй байх, зэвсэг нийлөөлөхгүй байх, нийлөөлөх тохиолдолд ялгаварлахгүй байх,
 - дөрвөгчдийг хөдлөн авах ба аль нэгэн талд шилжөөлөхгүй байх.

Эдгээ Швейцар, Австри, Камбож, Туркменистан, Мальта, Коста-Рика зэрэг нэлээд хэдэн улс “байнга төвийг сахих” статусаа хадгалж байна.

Төвийг сахих статус хадгалж буй бусад улсын онцлог

Төвийг сахих статустай улс нэг бөрийн хувьд, ийм статус авах болсон шалтгаан, зорилгыг дараах зарим орны жишээн дээр товч тайлбарлавал:

Швейцарийн төвийг сахих статусын онцлог. Швейцар улсыг, төвийг сахих статустай улсын “сонгодог жишээ” хэмээн дэлхий нийтээр хөдлөн зөвшөөрдөг. Европт олон жил өргөлжилсэн дайны асуудлыг зохицуулах зорилгоор Австри, Франц, Их Британи, Орос, Прусс (Герман), Португал зэрэг улс 1815 оны 11 дүгээр сарын 08-нд хийсэн уулзалтаар, Швейцар улсаар төвийг сахиулах тухай гэрээг анх байгуулсан байдаг. Ингэхдээ дээр дурдсан улс орнууд, Швейцарийн “байнгын төвийг сахих” статусыг хөдлөн зөвшөөрөхийн зэрэгцээ, энэ байдал нь алдагдах буюу нутаг дэвсгэрт өөр улс орон халдан довтлох тохиолдолд тэднийг хамгаалахаар тохиролцсон байдаг.

Улмаар тус улсын төвийг сахих статус бэхжиж, 1919 онд Версалийн “Энхийн гэрээ”-гээр баталгаажсан төгөхтэй. Энэ нь олон өндэстэн, ястан, хэлтнээс бөрдөх Швейцарийн холбооны улсын яс өндэс, хэлний өвөрмөц байдал онцлогийг зохицуулахад ихээхэн хувь нэмэртэй болжээ. Өөрөөр хэлбэл, дотоод асуудлаа шийдвэрлэх гэсэн Швейцарийн зорилго нь, төгөөр төвийг сахиулах гэсэн их өргөө дийн ашиг сонирхолтой нийцсэн байна.

¹²⁷ Америк тив дэх “төвийг сахих” статустай цорын ганц улс бөгөөд 1948 оноос зэвсэгт хөгчнөө

ашиглахгүй гэдгээ зарлаж 1949 оноос байнга төвийг сахих болжээ.

Австрийн тvvийг сахих статус. 1955 оны “Москлагийн меморандум”-аар Австри улс байнга тvvийг сахих vvрэг хvvлээсэн байдаг.

Тодруулбал, АНУ, Их Британи, Франц, ЗХУ-ын зvvгээс 1955 оны 04 дvvгээр сарын 15-нд, Австритай “Тvvийг сахих тухай” гэрээ байгуулсныг мvvн оны 12 дугаар сарын 26-ны vvдvvр тус улсын Парламент соёрхон батласан байдаг.

Дэлхийн II дайны дараа, Австрийг чvvлvvлсvvн Холбоотнуудын¹²⁸ зvvгээс, тус улсыг vvрийн “блок”-тоо элсvvлэх бодлого, санаархал эрчимжсэн байна. Тухайн vvдээ хэрэв энэ vvрсvvлдvvн даамжрах аваас, Германы адил хоёр хуваагдах эрсдэл Австрид нvvрvvлээд байв. Тус улсын хувьд тусгаар тогтнол, газар нутгийн бvvрэн бvvтэн байдлыг хадгалж vvлдэх цорын ганц зvvв арга зам бол хэн хэнийнх нь ашиг сонирхлыг илэрхий хvvндvvхvvй байх явдал байлаа. Иймээс, тус улс тvvийг сахих замыг сонгосон байна.

Лаосын тvvийг сахих статус. Олон улсын амьдралд, колонийн тогтолцоог халах vvйл явц идэвхижсэний vvр дvvнд, 1961 оны 05 дугаар сарын 26-ны vvдvvр Женев хотноо Лаос, БНАВУ, Камбож, ЗХУ, АНУ, Их Британи, Франц, БНХАУ, Энэтхэг, Польш, Канад, Мянмаар, Таиланд, vvмнд Вьетнам оролцсон бvvрэлдэхvvнтэйгээр Лаосын асуудлыг авч хэлэлцсэн Зvvвлvvлийн ажиллагаа эхлэжээ. Улмаар 1962 оны 07 дугаар сарын 23-нд тус Зvvвлvvлvvс, “Лаосын тvvийг сахих Тунхаглал”-ыг батлгаж, энэ нутгаас гадны цэргийн хvvч, албан хаагчдыг гаргах, vvрийгvv хамгаалах хvvчний хэрэгцээнд ердийн зэвсэгтэй байх тухай шийдвэр гаргасан аж. Гэвч уг тунхаглалыг зарласны дараахнаар, тус улсад иргэний дайн гарч, генерал Купрасит Абха болон Сихо нар тvvрийн эргэлт хийв. vvvvнийг эсэргvvцсэн АНУ-ын нисэх хvvчин Лаосын зvvн vvмнд нутагт довтолсон явдал Вашингтоны зvvгээс тус улсын тvvийг сахих статусыг vvл хvvндэтгэсэн хэрэг болсон байна.

Камбожийн тvvийг сахих статусыг хvvлээн зvvвшvvрvvх vvйл явц. Олон жил Франц, Японы колоничлолд байсан энэ улс, тvvийг сахих статустай болох тухай шийдвэрийг Женевийн зvvвлvvлvvс 1954 онд гаргасан юм. Улмаар Камбож улс “тvvийг сахих” статусаа 1957 оны 11 дvvгээр сарын 06-нд vvндсэн хуулиараа зарласан байдаг. Гэвч бодит байдал дээр бол энэ улсын тvvийг сахих статусыг олон улсад хvvлээн зvvвшvvрvvгvvй юм.

1970 онд гарсан тvvрийн эргэлтийн дараа АНУ, цэргээ дахиад Камбожид оруулсан байдаг. Ингэж, Камбожийн тvvийг сахих статусаа хvvлээн зvvвшvvрvvлэх гэсэн эрмэлзэл, тvvний vvйл явц 34 жил vvргэлжилсний эцэст,

¹²⁸ ЗХУ болон НАТО

1991 оны 11 дүгээр сарын 23-нд Парисын гэрээ байгуулагдсанаар биелсэн байна.

Туркменистаны байнга тэвгийг сахих статус. Тус улс 1995 оны 12 дугаар сарын 12-ны дүр нэгдсэн хуулиндаа өөрчлөлт оруулж, байнга тэвгийг сахих статусаа нэгдсэн хуулиараа зарласан. Энэ гадна, Тэвгийг сахих статусаа дэлхийн хамтын нийгэмлэгээр хэлээн зөвшөөрүүлж, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоол гаргуулж чадсан цорын ганц улс. Туркменистаны тэвгийг сахих статусыг 1995 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хуралдаанд оролцогч 185 улс санал нэгтэй хэлээн зөвшөөрсөн байдаг¹²⁹.

Ашгабат, улс төрийн утгаар төдийгүй эдийн засгийн харилцаандаа тэвгийг сахих тухай хуульчилсан онцлогтой¹³⁰. Ингэснээр, Туркменистан улс нэгдсэн хууль, Байнга тэвгийг сахих хууль болон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоол гаргуулж тэвгийг сахиснаар олон улсын хамтын ажиллагааны олонх хэлбэрээс татгалзаж, “ганцаардмал байдалд орсон” гэх шүүмжлэл байдаг.

Дурдсан улс орны тэвгийг сахих статустай болсон асуудлыг үйл явц, үр дүн талаас задлан шинжилж товч дүгнэвэл:

- тэвгийг сахих статусыг зарлах, баталгаажуулах явдалд их гэрний ашиг сонирхол ихээхэн нөлөөтэй нь харагдаж байна;

- тэвгийг сахих статусыг хэлээн зөвшөөрөх явцад, их гэрний ашиг сонирхлыг нэгтгэх ажиллагаа удаан хугацаанд өргөлжилж болзошгүй байна;

- тэвгийг сахих статусыг хадгалах хэсэг зорилготой улс, төр засгийн хувьд дотооддоо эв нэгдэлгүй, аливаад нэгдмэл байр суурьтай болж чадаагүй, асуудалд хариуцлагагүй хандах аваас, их гэрний ашиг сонирхлыг “хөгдсөн” тохиолдол болж, төрний энэ статусыг аливаа их гэрэн “өл ойшоох” байдалд хүрч болзошгүй байна;

- тэвгийг сахих статусаа хэт нарийвчлан “хуульчлах” гэх мэт тохиолдолд олон улсын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагааны гадна хоцорч, улмаар ганцаардмал байдалд орох “эрсдэл” тулгарч магадгүй байна.

Монгол улсын тэвгийг сахих статус, онцлог ба нэгдсэн ойлголт

¹²⁹ 1995 оны 12 дугаар сарын 12-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблен 50/80 тоот тогтоол гарч, Туркменистаны байнга тэвгийг сахих статусыг хэлээн зөвшөөрчээ.

¹³⁰ Эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд тэвгийг сахина, гэсэн тохиолдол урьд нь гарч байгаагүй.

Аливаа шинжлэх ухааны мэдлэг мэдээлэл толь бичгээс эхлэдэг. Манай нэрт эрдэмтэн, хэл шинжээч Я.Цэвэл гуайн тууригсан “Монгол хэлний тайлбар толь”-д “төвийг сахих” гэдгийг “...аль нэг талд орохгүй, цэх шударга байх...” хэмээн тодорхойлсон байдаг¹³¹.

Төвийг сахих тухай төл бодол, Монгол Улсын хувьд цоо шинэ ойлголт биш.

Ардын засгийн анхны жилүүдэд Монгол Улс төвийг сахих тухай төл санаа оршиж байсныг бид мэднэ. Тухайлбал, 1930 оны эхээр Ц.Жамсран, Б.Цэрэндорж нар “...Монгол Улс, Швейцар лугаа хөгжин” хэмээн зарлаж байсан удаатай.

Харамсалтай нь, тухайн төд Коминтернийн илт шахалтад автаж, энэ зорилт бодитой хэрэгжиж чадаагүй юм. Харин “Хөйтэн дайн” эцэслэж, Монгол Улсад ардчилсан хөдөлгөөн өрнөж, улмаар Монгол Улс бие даасан гадаад, дотоод бодлого явуулдаг болсон 1990-ээд оноос хойш Монгол Улс төвийг сахих статусыг “де-факто” баримтлаж ирсэн байдаг.

Өөрөөр хэлбэл, энэ статусын суурь зарчим Монгол Улсын төндсөн хууль, төндсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын төл баримтлалд тусаж, хадгалагдсаар буй хэмээн төзж болно. “Монгол Улс байнга төвийг сахих тухай хууль”-ийн төслөд эдгээр суурь зарчмыг нэгтгэж, уялдуулсан гэж төзж, ойлгож болно. Энэхүү хууль батлагдсанаар Монгол Улсын байнга төвийг сахих статусыг хадгалах арга зам, эрх зөлийн хувьд манай хоёр хөрш болон бусад төнш улсад илүү ойлгомжтой болох юм. Уг хуулийн төслийн дөрвдөгээр зөйлд заасны дагуу Монгол Улсын “Байнга төвийг сахих” статус гэдгийг аливаа дайн, зэвсэгт мөргөлдөөнд оролцохгүй, энхийн цагт цэргийн эвсэл, холбоонд нэгдэхгүй байх явдал хэмээн ойлгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын төвийг сахих байр суурь зөвхөн улс хоорондын дайн, эсвэл зэвсэгт мөргөлдөөний төд хэрэглэгдэх бөгөөд бусад тохиолдолд чөлөөтэй, бие даасан гадаад бодлогоо хэрэгжүүлэхэд нөлөөлөхгүй, гэж ойлгож болно.

Гадаад бодлогын тухайд

Монгол Улс байнга төвийг сахих статус баримтлах болсныг гадаад бодлогын өөрчлөлт хэмээн төзж, ташаа ойлгож болохгүй. Ерөөсөө, төвийг сахих статус бол бодлого биш харин олон тулгуурт гадаад бодлогыг

¹³¹ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. БНМАУ-ын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо. Улаанбаатар. 1966 он.

хэрэгжүүлэх нэгэн арга хэрэгсэл. Өөр хэлбэл, Монгол Улсын байнга твийг сахих статус бол Монгол Улсын тусгаар тогтнолыг хамгаалж, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэхэд чиглэсэн гадаад бодлогын үйл ажиллагааны нэгэн шинэ хуульчлал юм.

Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд тусгасан, олон тулгууртай байх, энхийг эрхэмлэх, гадаадын цэргийн хүчнийг өөрийн нутагт үл байршуулах зэрэг зарчим “Твийг сахих статус”-тай нийцэж байгаа твийг эдгээр зарчимд тулгуурласан гадаад бодлогын зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд бодит дэмжлэг болно, гэж үзэж байна.

Энэ статусыг хадгалснаар Монгол Улсын гадаад бодлогод өөрчлөлт орохгүй, харин ч олон улстай тэнцвэртэй харилцах зарчим улам бэхжих боломжтой юм. Ялангуяа, ОХУ болон БНХАУ-тай хөгжүүлж буй стратегийн түншлэлд өөрчлөлт орохгүй хэмээн ойлгож болно. Энэ тухай “Монгол Улс байнга твийг сахих тухай хууль”-ийн төслийн 3.1-т тодорхой заасан байна.

Монгол Улс, твийг сахих статусаа зарласан гол зорилго бол хоёр хүрштэйгээ эн тэнцүү харилцахаа дахин нотлож байгаа хэрэг бөгөөд 25 жил “де факто” сахиж ирсэн статусаа “де юре” болгож хадгалах явдал болно хэмээн судлаачийн хувьд үзэж байна. Монгол Улс хоёр болон “Туравдагч хүрш”-тэйгээ хариуцлагатай харилцах байдлаа, твийг сахих статусаар хадгалах явдал хамгийн эв арга зам болно.

Олон улсын харилцаанд Монгол Улс твийг сахих явцдаа, сүргэлцэж буй улс орнуудын аль нэгний талд орохгүй, тэдэнтэй ижил тэнцүү харилцах, хандах зарчмыг баримтлана. Гэсэн хэдий боловч энэ нь манай улсын болон олон улсын хууль, НҮБ-ын дүрэм, бусад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээг зүрчиж бусад улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд зэвсгийн хүчээр халдсан үйлдлийг эсэргүүцэх, шүүмжлэх эрхийг хязгаарлахгүй. Түүнчлэн Монгол Улс нэн төрөөнд улс орны тусгаар тогтнолыг хамгаалж, бүрэн эрхт байдлаа бэхжүүлэх зорилгоор твийг сахих байр суурийг баримтлах ба твийг сахих статус дээрх зорилгод харшлах нөхцөл байдал үүсэх аваас уг статусыг цуцлах эрх, Монгол Улсад нээлттэй хадгалагдана.

Энэхүү статусыг хадгалснаар, олон улсын тавцанд энхийг эрхэмлэсэн Монгол Улсын нэр хүнд өсч, энх тайвныг хадгалах, тогтоох чиглэлд олон улсын хамтын нийгэмлэгийн үйл хэрэгт идэвхитэй оролцох, твийг сахисан бусад улс орнуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж бүрдэх давуу талтай байна.

Батлан хамгаалах салбарын тухайд

Монгол Улс Үндсэн хуулиараа "Үүрийг хамгаалах зэвсэгт хүчинтэй байна" хэмээн тунхагласан байдаг. Түүнчлэн Үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын Үзэл баримтлалдаа олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх зүйн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулахыг тодорхойлсон явдал батлан хамгаалах бодлогын Үндэс. түүнийг сахисан олон тулгуурт цэргийн хамтын ажиллагааг хүгжүүлэх суурь болсон юм.

Түүнийг сахих статусын тухай суурь зарчим, тунхаглал болох энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулах, энхийн цагт цэргийн эвсэл холбоонд нэгдэхгүй байх, нутаг дэвсгэрээ бусдын эсрэг ашиглуулахгүй, дайтагч талуудад туслахгүй, үүрийн нутагтаа гадны цэргийн хүчийг байрлуулахгүй, дамжин нугрүүлэхгүй, цөмийн зэвсгээс ангид байх зэрэг зорилт улс орны батлан хамгаалах бодлогыг боловсронгуй болгож, үүрийг хамгаалах зэвсэгт хүчнээ хүгжүүлэх шаардлагыг бий болгоно. Үүний дагуу манай батлан хамгаалах салбарын хоёр болон олон талт хамтын ажиллагааг улам бүр хүгжүүлэх шаардлагатай болсон бөгөөд Үнд Монгол Улсын түүнийг сахих статус нөхцөл хүлээн үзэж байна. Учир нь, Зэвсэгт хүчнээ бэхжүүлэн хүгжүүлэх явдал нэгдгээрт, үүрийг хамгаалах, хоёрдугаарт дэлхий дахины энх тайван, аюулгүй байдлыг хангах, улмаар түүнийг сахих байр суурийн илэрхийлэл болно. Энэ ч үүднээс Монгол Улсын байнга түүнийг сахих статус батлан хамгаалах салбарт сөрөг нөхцөл үзүүлэхгүй хэмээн үзэж байна. Үүнийг батлан хамгаалах салбарын бодлогын эрх зүйн Үндэс болох "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын Үндэс" болон Монгол Улс байнга түүнийг сахих тухай хуулийн төсөл зэрэг баримт бичигт тусгасан юм.

Ерөөс түүнийг сахих тухай нэгдсэн загвар байдаггүйн дээр тухайн улс үүрийг хамгаалах бөхий л арга хэрэгсэл түүний дотор цэргийн хүчээр үүрийг хамгаалах эрх ашгийг гүйцгэдэггүйгээрээ онцлогтой. Түүнчлэн түүнийг сахих улсын нутаг дэвсгэр бөхөлдээ эсвэл хэсэгчлэн цэргийн аюулд өртөх тохиолдолд зэвсэгт хүчнээр үүрийг хамгаалах эрхээ хуульчлан баталгаажуулж, олон улсаар хүлээн зөвшөөрүүлсэн байдгаараа мөн өвөрмөц онцлогтой болно.

Сонгодог түүнийг сахигч Швейцарь улс гэхэд чадварлаг армитай бөгөөд бөх нийтийн батлан хамгаалах сайн тогтолцоотой орон гэдгийг бид бөгд мэднэ. "Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын Үндэс" баримт бичигт

манай улс бэх нийтийн батлан хамгаалах тогтолцоотой байхаар¹³² заасан явдал тэвгийг сахих зарчимд нийцэж байна.

Тэвгийг сахиснаар Монгол Улс аль нэг улс оронтой бусдаас илүү тэвшинд цэрэг техникийн хамтын ажиллагааг явуулахаас татгалзах, цэргийн худалдаа зэвсэг техникийн засвар үйлчилгээ, сэлбэг нөөцийн бэлдэлтийг нэг талаас хэт хамааралтай бус байлгах боломжтой болно. Ингэснээр Зэвсэгт хүчний зэвсэг техникийн шинэчлэл, техникийн тусламж гаднаас авах эрхээ хадгалж байна.

Тэвгийг сахиснаар Монгол Улсын гадаад бодлого, гадаад хамтын ажиллагаанд зарчмын үрчлэлт орохгүй тул Дэлхий дахины терроризмын эсрэг тэмцэл болон хүний эрхийг хамгаалах үйлсэд болон НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаан дахь оролцоогоо хадгалах тэдийгүй хэлбэр агуулгыг нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа идэвхжүүлэх бэрэн эрхтэй юм. Энэхүү эрхээ Монгол Улс байнга тэвгийг сахих тухай хуулийн төсл¹³³ болон Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс¹³⁴ зэрэг баримт бичигт суулгаж үгсэн юм. Үүрэг хэлбэл, НҮБ-ын мандаттай энхийг дэмжих ажиллагаа тэдийгүй НҮБ-ын аюулгүйн зөвлөлийн зөвшөөрсөн олон улсын бусад ажиллагаанд НҮБ-ын дүрмийн VI, VII бүлгийн аль алины үйлчлэлд хамаарах хүрээнд оролцох нөхцөл боломжтой. Тодруулбал, НҮБ-ын мандаттай “peace keeping” ажиллагаанд оролцоор байна. Харин мэргэлдэнтэй бүс нутагт бусад тэвгийг сахих улсын адилаар “peace making” буюу энхийг тогтоох үйл ажиллагааг санаачлахгүй, явуулахгүй болно. Иймээс Монгол Улсын Энхийг сахиулах үйл ажиллагаа цаашид өргөлжилж, Монгол Улс хариуцлагатай, идэвхтэй тэвгийг сахих байр суурийг баримтлана. Түүнчлэн үүн нь Монгол Улсаас бусад улстай хөгжүүлж ирсэн батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаанд зарчмын үрчлэлт орохгүй болно.

Дүгнэлт

Нэн тэргүүнд “Тэвгийг сахих” статус бол бодлого бус харин манай олон тулгуурт гадаад бодлогыг хэрэгжүүлэх нэгэн хэрэгсэл гэдгийг олон нийт, иргэдэд ойлгуулах хэрэгтэй юм. Түүнчлэн тэвгийг сахих статусыг зарлах болон баталгаажуулахад их гүнзгий ашиг сонирхол ихээхэн нөхцөлдөг тул хоёр хүршд нь Монгол Улсын баримтлах тэвгийг сахих статусыг онцгойлон тайлбарлаж итгүүлэх хэрэгтэй байна.

¹³² Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс 2.2

¹³³ Монгол Улс байнга тэвгийг сахих тухай хуулийн төслийн 1.5

¹³⁴ Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс 3.2.8

Түүний зэрэгцээ Төвийг сахих статус бол олон улсын мөнх хэлээх том хариуцлага. Өөрөөр хэлбэл идэвхгүй аливаа асуудлаас хол байхын нэр биш. Төвийг сахих улс орон, дотооддоо эв нэгдэлгүй, аливаад нэгдмэл байр суурьгүй. асуудалд хариуцлагагүй хандах аваас, их гэрээний ашиг сонирхлыг хндсн тохиолдолд сэх нь хялбар бөгөөд түүний статусыг их гэрээнд л хндэтгэх нхцлд хрэх боломжтойг анхаарах нь чухал байна.

Байнга төвийг сахих улс, хоёр талын улс төр, эдийн засаг, батлан хамгаалах харилцааг бэхийл төвшинд хгжлэх бэрн боломжтой. Өөрийгөө хамгаалах зэвсэгт хчнийг бэхжлэх, хгжлэх өднээс хоёр болон олон талт хээрийн сургуулийг зохион байгуулж, хамтран оролцох эрхтэй хэвээр байх болно.

Монгол Улс НБ-ын мандаттайгаар энхийг сахиулах /peace keeping/ үйл ажиллагаанд нэгдэн орох боломжтой. Харин энхийг тогтоох /peace making/ ажиллагаанд оролцохгүй байвал оновчтой. Түүнчлэн НБ-ын эдийн засгийн хориг арга хэмжээнд нэгдэх эрхтэй байна.

Байнгын төвийг сахих статус бол мөнхийн байр суурь биш. Төвийг сахих байр суурь нь, манай улсын эрх ашигт сргээр нлллх тохиолдолд түүнийг цуцлах эрх, Монгол Улсад хэдийд ч хадгалагдсан хэвээр байна.

Монгол Улсын хувьд байнга төвийг сахих статусаа хлээн звшлрлэхийн тулд Хаагийн 1907 оны V; XIII конвенцид даруй нэгдэх шаардлагатай болно.